

УЛСЫН БҮРТГЭЛИЙН БАЙГУУЛЛАГЫН АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ
ХАНГАХ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025.12.15

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа (улирал)	Хэрэгжилт
ЗОРИЛГО. Албан хаагчдын мэргэших, ажлын байрны болон амьдрах нөхцөл бололцоог сайжруулах, төрийн албан хаагчдыг сургах, ажлын байрны нөхцөл, нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх, эрүүл мэндийг хамгаалах нөхцөл боломжоор туслах замаар үе шаттайгаар тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэх.							
Зорилт 1. Төрийн албан хаагчдын албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх мэдлэг, ур чадвар, арга зүйг өргөн хүрээнд эзэмшүүлэх боломж, нөхцөлийг хангана.							
1.1.	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд төрийн захиргааны албан тушаалд нийтлэг болон тусгай шаардлага хангасан, төрийн албанд, тухайн албан тушаалын ангилал, зэрэглэлд ажилласан жилийг баримтлан албан хаагчдыг шатлан дэвшүүлж, хүний нөөцийн оновчтой бодлогыг хэрэгжүүлэх;	-	Сул орон тоонд томилогдсон албан хаагчийн тоо	0	25	I-IV	Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн гүйцэтгэх албан тушаалын 11 сул орон тоог нөхөх зорилгоор 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр төрийн албаны тусгай шалгалтыг зохион байгуулсан. Тусгай шалгалтад тэнцэж, хамгийн өндөр оноо авсан 6 иргэдийг Төрийн албаны зөвлөлийн Улсын бүртгэлийн ерөнхий газрын дэргэдэх Салбар зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 02 дугаар тогтоолоор албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлсэн.
1.2.	Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд чиглүүлэх богино хугацааны болон албан тушаалын мэргэшүүлэх сургалтын зардлыг байгууллагын төсөвт жил бүр тусгаж, сургалтын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн оновчтой зохион байгуулах;	Улсын төсөв	Зохион байгуулсан сургалтын тоо	-	4	I-IV	1.“Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах сургалт”-ыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн

							A/190 тушаал болон 2/86 дугаар удирдамжийн дагуу 2025 оны 01 дүгээр сард танхимын сургалтад нийт 9 албан хаагч, 2.Цахим хөгжил, инновац, харилцаа, холбооны яамнаас ирүүлсэн албан бичгийн хүрээнд 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр Хиймэл оюун ухааны бэлэн байдлын үнэлгээний хэлэлцүүлэгт 1 албан хаагч, 3.Авлигатай тэмцэх газар болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын ЭБАТ нар хамтран зохион байгуулсан сургалтад 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын нийт 15 албан хаагч, нийслэл орон нутгийн 62 нийт 77 албан хаагч, 4.Дотоод Хэргийн Их Сургуулиас 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан Цахим сургалтын платформ дээр салбарын албан хаагчдыг хэрхэн яаж бүртгүүлэх, юунд анхаарч ажиллах талаарх сургалтад 4 албан хаагч, 5.“Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарт зориулсан сургалт”-ыг танхим болон цахимаар зохион байгуулж, 27 албан хаагч танхимаар, Багахангай, Багануур, Налайх дүүрэг болон орон нутгийн улсын бүртгэлийн хэлтсийн эд хөрөнгийн улсын бүртгэгч, улсын
--	--	--	--	--	--	--	---

							ахлах бүртгэгч 100 албан хаагч цахимаар, 6.Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хаагч нарт “Уран зохиол, утга найрууллын сургалт”-ыг сургалтад 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр нийт 150 албан хаагч цахимаар, 7.Мэдээллийн технологийн албан хаагчдад блокчэйн технологи, хиймэл оюун ухаан (Ai), машин сургалт, тэдгээрийн хэрэглээний талаар онолын мэдлэг олгох танхимын сургалтад 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Мэдээллийн технологийн газрын 15 албан хаагч, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/43 тушаалын дагуу Улсын бүртгэлийн байгууллагын төрийн захиргааны албан тушаалд шинээр томилогдсон албан хаагчдыг чиглүүлэх, дадлагажуулах сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс 04 дүгээр сарын 03-ний өдрүүдэд батлагдсан 1/58 дугаарын удирдамжийн дагуу зохион байгуулж, сургалтад нийт 14 албан хаагч хамрагдсан. 8.Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас ирүүлсэн 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01/325 дугаар албан бичгийн хүрээнд Улсын
--	--	--	--	--	--	--	--

							үнэлгээний чадавхын индекс тогтоох үнэлгээний асуумж хэрхэн бөглөх, мэдээлэл зөвлөгөө өгөх сургалтад Улсын бүртгэлийн ерөнхий газрын газар, хэлтсийн дарга нар цахимаар хамрагдсан. Сургалтад нийт 5 газар, хэлтсийн дарга, Бодлого төлөвлөлт, дүн шинжилгээний газрын 1 ахлах мэргэжилтэн, 1 мэргэжилтэн нийт 7 албан хаагч хамрагдсан. 9.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 03 сарын 24-ний өдрийн А/46 дугаар тушаалын дагуу Улсын бүртгэлийн байгууллагын удирдах ажилтны сургалт, зөвлөгөөнд нийт Улсын бүртгэлийн байгууллагын 79 удирдах албан хаагч оролцсон. 10.Удирдлагын академиас зохион байгуулсан “Хос бичгээр баримт бичиг боловсруулах арга зүй” “сэдэвт сургалтад 2025.04.14-ний өдрөөс 15-ны өдрүүдэд Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч 4, ахлах архивч 1 нийт 5 албан хаагч, 11.Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолоор баталсан “Кибер аюулгүй байдлыг ахнгах нийтлэг журам”-ын хэрэгжилтийг хангахаар Мэдээллийн технологийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, бүртгэлийн байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах
--	--	--	--	--	--	--	--

							зорилгоор бүхий сургалтад 2025 оны 04 дүгээр сарын 17, 18-ны өдрүүдэд нийт 46 мэдээллийн технологийн албан хаагч, 12.БНХАУ-ынэлчин сайдын яам, Хятадын худалдааны яам болон Олон улсын бизнесийн академи(AIBO)-тай хамтран зохион байгуулсан Нэг бүс нэг зам дагуух улс орнуудын төрийн албан хаагчдад зориулсан Шинэ дэд бүтэц технологи ба менежмент сэдэвт сургалтад 2025.04.17-30-ны өдрүүдэд 2 албан хаагч, 13.“И-Монгол академи” УТҮГ-тай хамтран зохион байгуулсан сургалтад 2025.04.29-ны өдөр Улсын бүртгэлийн ерөнхий газрын 57 албан хаагч, 14.НДЕГ-тай хамтран Нийгмийн даатгалын багц хуулийг сурталчлан таниулах сургалтад 2025.05.12-ны өдрүүдэд 25 албан хаагч, 15.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/82 тоот тушаал, Тамгын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Албан хаагчдын мэдлэг ур чадварыг дэмжин танин мэдэхүйн мэдлэг мэдээллийг дээшлүүлэх, улсын бүртгэл хөтлөх, Аймаг,нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн тухай
--	--	--	--	--	--	--	---

							хуулийг хэрэгжүүлэх орон нутгийн нөхөн сонгуулийг зохион байгуулахад анхаарах асуудлын хүрээнд дэмжлэг үзүүлэх, төрийн албан хаагчийн ур чадавхийг бэхжүүлэх” сургалтын удирдамжийн хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд 97 албан хаагч, 16.Улсын Ерөнхий Прокурорын газраас Зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, харилцан мэдээлэл солилцох, Зөрчлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор зохион байгуулсан сургалтад Хяналт шалгалтын улсын (ахлах) байцаагч, хяналтын улсын байцаагч нийт 30 албан хаагч, 17.Удирдлагын академийн “Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх” сэдэвт сургалтад 2025.06.04-ний өдрөөс 05-ны өдрийн хооронд 3 албан хаагч хамрагдсан. 18.Удирдлагын академийн сургалтад төсвийн зардлаар ахлах түшмэлд 1, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 1,мэргэшүүлэх дунд хугацааны сургалт 3 чиглүүлэх сургалтад 5 нийт 10 албан хаагч 19.Удирдлагын академийн сургалтад хувийн зардлаар эрхэлсэн түшмэлийн багц
--	--	--	--	--	--	--	---

							сургалтад 1, ахлах түшмэлийн багц сургалтад 5, дунд хугацааны давтан сургалтад 4, нийт хувийн зардлаар 10 албан хаагч, 20.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 тоот тушаалаар АЕГ-ын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах сургалтад 2025 онд 13 албан хаагч хамруулахаар төлөвлөсөн. 06 дугаар сарын байдлаар 7 албан хаагч хамрагдсан. 2025.06.04-нөөс 05-ны өдрүүдэд Удирдлагын академийн “Төрийн албан хаагчийн сургалт, хөгжлийн хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх” сэдэвт сургалтад 3 албан хаагч хамрагдсан. 06 дугаар сарын 08-ны өдрийн 2-3/07 дугаарт илтгэх хуудсаар танилцуулагдсан 21.2025.06.10-ны өдрийн 10.00 цагт ХЭУБГ-ын улсын ахлах байцаагч Б.Лхагвасүрэн Гадаадын иргэн, харьяатын газарт “Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэхэд анхаарах асуудал” сэдвийн хүрээнд сургалт зохион байгуулсан. 22.2025.06.27-07.05-ны өдрийн хооронд Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд хэрэгжиж буй "Сумдад эд
--	--	--	--	--	--	--	---

							хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах" төслийн санхүүжилтээр Австралийн холбооны улсын ижил чиг үүргийн байгууллагуудын сайн туршлага судлахаар 8 албан хаагч хамрагдсан. 07 дугаар сарын 24-ний өдөр илтгэх хуудсаар таницуулагдсан. 23.2025.03-06 дугаар сарын хугацаанд Олон нийттэй харилцах мэргэжилтэн бэлтгэх, мэргэшүүлэх сертификаттай сургалтад ХАСХ-ийн график, дизайнер Н.Сумьяасүрэн хамрагдсан. Сургалтаар олон нийттэй харилцах үйл ажиллагаанд гэрэл зураг, видео контентыг засварлах, монтаж хийх ур чадвар эзэмшсэн. 06 дугаар сарын 09-ний өдрийн 2-3/01 илтгэх хуудсаар танилцуулагдсан. 24.Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/05 тоот тушаалаар АЕГ-ын архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтныг мэргэшүүлэх, давтан сургах сургалтад 2025 онд 13 албан хаагч хамруулахаар төлөвлөсөн. 11 дүгээр сарын байдлаар 10 албан хаагч сургалтад хамрагдсан. (Нийт 37)
--	--	--	--	--	--	--	---

							25.2025 оны 06 дугаар сарын 30-наас 07 дугаар сарын 06-ны өдрийн хооронд Смарткарт ХХК-тай байгуулсан "Иргэний цахим үнэмлэх хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдах, худалдан авах" 2024/34-Н дугаартай гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Бүгд Найрамдах Турк улсын Истамбул хотод байрлах Энтраст компанийн салбарт "Хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тохиргоо, засвар үйлчилгээ"-ний сургалтад 4 албан хаагч хамрагдсан. 07 дугаар сарын 08-ны өдрийн 1/182 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан. (Нийт 4) 26.2025.08.18-ны өдрийн 1/190 дугаартай удирдамжаар Төрийн байгууллагын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем (ERP-e mongolia.mn)-ийн талаар сургалт зохион байгуулсан. Сургалтад танхимаар 30, цахимаар 44, нийт 74 албан хаагч хамрагдсан. 08 дугаар сарын 22-ны өдрийн 2-3/03 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан. 27.2025.08.25-ны өдөр Дархан-Уул аймгийн УБХ-ийн албан хаагчдад Архивын лавлагаа олгоход анхаарах асуудал сэвдээр УБНА-ын хэлтсийн мэргэжилтэн Г.Дуламсүрэн мэдээлэл хүргэн ажилласан.
--	--	--	--	--	--	--	---

							Нийт 10 албан хаагч хамрагдсан. (Нийт 87) 28.2025.09.19-ний өдрийн 1/230 дугаарт удирдамжаар Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчдад Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 7 дугаар зүйл байгууллагын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, тэдэнд ойлгох, түргэн шуурхай үйлчлэхэд мэдлэг мэдээлэл өгөхөд чиглэсэн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад цахимаар аймаг, дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн 100, танхимаар төв байгууллагын 36, нийт 136 албан хаагч хамрагдсан. 09 дүгээр сарын 19-ний өдрийн 1/258 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан. 29.2025.09.12-ны өдөр СААХ-ээс Хууль зүй, дотоод хэргийн салбарын санхүү, нягтлан бодох бүртгэлийн нэгдсэн e-accounting.mojha.gov.mn системийн нэвтрүүлэлт, анхаарах асуудал, нийслэлийн улсын бүртгэлийн 9 дүүргийн харьяаллын өөрчлөлт, тайлан мэдээ нэгтгэл, төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын pcspp.gov.mn цахим системт
--	--	--	--	--	--	--	---

							төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын хуулийн этгээдийн болон өмч хөрөнгийн мэдээллийг нээлттэй байршуулах явц, анхаарах асуудал, 2024 оны санхүүгийн тайлангийн аудитын биелэлт, fas.audit.mn-д байршуулах талаарх мэдээлэл өгөх цахим сургалтыг 21 аймаг, 9 дүүргийн УБХ-ийн дарга, ахлах нягтлан бодогч, нярав нарт зохион байгуулсан. Сургалтад нийт 90 албан хаагч хамрагдсан. <i>09 дүгээр сарын 15-ны өдрийн 2-3/04 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан.</i> 30.2025.09.17-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн улсын бүртгэлийн хэлтсээс Иргэний улсын бүртгэлийн газарт гаргасан хүсэлтийн дагуу “Иргэний улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал” сэдвийн хүрээнд иргэний улсын /ахлах/ бүртгэгч нарт зориулсан сургалтыг дүүргийн Нутгийн захиргааны төв байрны сургалтын танхимд 17:30-19:00 цагийн хооронд зохион байгуулсан. Сургалтад дүүргийн улсын бүртгэлийн хэлтсийн Сонгинохайрхан төв, Драгон төв, Өнөр цэг, Баянхошуу төв, Толгойт төвийн улсын ахлах бүртгэгч 5, улсын бүртгэгч 19, нийт 24 албан хаагч хамрагдсан. 31.2025.09.26-ны өдөр Хуулийн этгээдийн улсын бүртгэгчийг
--	--	--	--	--	--	--	---

							чиглүүлэх сургалтыг ХЭУБГ-аас зохион байгуулсан. Сургалтад ХЭУБГ-ын улсын бүртгэгч (ахлах), дүүргийн УБХ-ийн улсын ахлах бүртгэгч нийт 40 албан хаагч хамрагдсан. 32.2025.09.29-10.10-ны өдрүүдэд “Үйлчилгээний ур чадвар”-ын 6 удаагийн сургалтыг зохион байгуулсан. Танхимаар СБД-ийн УБХ-ийн 40, цахимаар Багахангай, Багануур, Налайх дүүргийн УБХ-ийн 28, БЗД-ийн УБХ-ийн 51, БГД-ийн 31, СХД-ийн 58, ХУД-ийн 29, ЧД-ийн 36, нийт 273 албан хаагч сургалтад хамрагдсан. 33.2025.09.29-ний өдрийн 1/254 дугаартай удирдамжаар “Аз жаргалтай, бүтээмжтэй ярилцахуй” сэдэвт сургалтыг зохион байгуулж төв байгууллагын 88 албан хаагч сургалтад хамрагдсан. 09 дүгээр сарын 29-ний өдрийн 2-3/05 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан. 34.2025.09.29-ний өдөр Төрийн албанаас хувийн хэвшилд шилжин ажиллахыг дэмжих өдөрлөгийг Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санаачлан зохион байгуулсан. Энэхүү өдөрлөгт 10 албан хаагч хамрагдсан. 35.2025.09.22-10.03-ны өдрийн хооронд Шинэ томилогдсон албан хаагчдын сургалтыг
--	--	--	--	--	--	--	--

							зохион байгуулсан. Сургалтад 13 аймгийн УБХ-ийн нийт 16 албан хаагчид хамрагдсан. 10 дугаар сарын 06-ны өдрийн 1/280 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан. 36.Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад 6 албан хаагч хамрагдсан: (Нийт 684) 37.2025.10.01-ний өдрийн 1/264 дугаартай удирдамжаар Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах тухай хуулийн 7 дугаар зүйл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцах анхан шатны харилцааны арга зүйг олгох, дохионы хэлний анхан шатны мэдлэгтэй болгоход чиглэсэн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 17 нэгжийн 34 албан хаагч оролцсон. 10 дугаар сарын 06-ны өдрийн дугаар 1/276 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан. 38.2025.10.08-ны өдөр Дотоод Хэргийн Их Сургуулиас зохион байгуулсан Цахим сургалтын платформ дээр салбарын албан
--	--	--	--	--	--	--	--

							хаагчдыг хэрхэн яаж бүртгүүлэх, юунд анхаарч ажиллах талаарх сургалтад 2 албан хаагч хамрагдсан. 10 дугаар сарын 10-ны өдрийн 1/295 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан. 39.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх залуучуудын оролцоо сэдэвт чуулганд 9 албан хаагч хамрагдсан. 10 дугаар сарын 10-ны өдрийн 1/296 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан. 40.2025.10.08-ны өдөр МУИС-аас зохион байгуулж буй олон улсын лекц, хэлэлцүүлэгт Тамгын газрын ХАСХ-ийн мэргэжилтэн Б.Насанбаяр оролцсон. 41.2025.10.17-ны өдрийн байдлаар Монгол бичгийн анхан шатны хичээлийг 387, 2025.10.31-ний өдрийн байдлаар дунд шатны хичээлийг 131, 2025.11.12-ны өдрийн байдлаар 49, нийт 567 албан хаагч үзэж судалсан байна. 42.2025.10.23-ний өдрийн 1/326 тоот удирдамжаар Улсын бүртгэлийн байгууллагын брендбүүк танилцуулах сургалтыг зохион байгуулсан. Сургалтад танхимаар төв байгууллагын 56, цахимаар аймаг, дүүргийн УБХ-ийн 78, нийт 134 албан хаагч хамрагдсан.
--	--	--	--	--	--	--	---

							43.2025.10.27-ны өдрийн 1/12156 тоот албан бичгээр Удирдлагын академид хувийн зардлаар суралцах 16 албан хаагчийн мэдээллийг хүргүүлсэн. 5 албан хаагчийн сургалтын гэрээ ирсэн. 44.2025.10.29-ний өдөр 1/334 дугаартай удирдамжаар “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” цахим сургалтыг зохион байгуулж 73 албан хаагч сургалтад хамрагдсан. 10 дугаар сарын 31-ний өдрийн 1/347 тоот илтгэх хуудсаар танилцуулагдсан. (Нийт 828) 45.2025.11.05-07-ны өдрүүдэд А/203 дугаартай тушаалаар Улсын бүртгэлийн байгууллагын санхүүгийн албан хаагчдын нэгдсэн сургалтыг зохион байгуулсан. Санхүүгийн 40 гаруй албан хаагч сургалтад хамрагдсан. Улсын бүртгэлийн байгууллагын санхүүгийн албан хаагчдын нэгдсэн сургалт зохион байгуулагдаж байна burtgel.gov.mn 46.2025.11.05-ны өдөр 10 дугаар сарын 31-ний өдрийн 1/350 дугаартай удирдамжаар “Эд хөрөнгийн эрхийг улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудал, нотариатын зуучлалаар эрхийн улсын бүртгэл хөтлөх, мэдлэг, мэдээлэл олгох тухай” цахим сургалтыг зохион байгуулсан. Сургалтад цахимаар 240 гаруй,
--	--	--	--	--	--	--	--

							танхимаар 9, нийт 249 албан хаагч хамрагдсан. УБЕГ-ын Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын ээлжит сургалт боллоо burtgel.gov.mn 47.2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 4/3 тоот удирдамжаар 09.23-10.27-ны өдрийн хооронд Сумдын бүртгэгч нарт хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөхөд анхаарах асуудлын хүрээнд цахим сургалтыг ХЭУБГ-аас зохион байгуулсан. Сургалтад 8 аймгийн УБХ-ийн сумдын бүртгэгч нар сургалтад хамрагдсан бөгөөд 12 удаагийн сургалтаар 369 албан хаагч хамрагдсан. (Нийт 658)
1.3.	Албан хаагчдыг гадаад, дотоодын их, дээд сургуульд мэргэшүүлэх, давтан сургах, сургалтад хамрагдах хугацаанд цалин, урамшууллыг олгож дэмжлэг үзүүлэх, чөлөө олгох	Улсын төсөв	Дэмжлэг үзүүлсэн албан хаагчийн тоо	72	75	I-IV	1.БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА)-аас зохион байгуулсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх ээлжит сургалтад 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 14 өдрийн хооронд нийт 15 албан хаагч; 2.БНХАУ-ынэлчин сайдын яам, Хятадын худалдааны яам болон Олон улсын бизнесийн академи(AIBO)-тай хамтран зохион байгуулсан Нэг бүс нэг зам дагуух улс орнуудын төрийн албан хаагчдад зориулсан Шинэ дэд бүтэц технологи ба менежмент сэдэвт сургалтад

							2025.04.17-ны өдрөөс 30-ны өдрүүдэд 2 албан хаагч тус тус хамрагдсан. 3.2025.08.05-09.15-ны хооронд БНЭУ-ын ЗГ-ын Энэтхэгийн Техникийн эдийн засгийн хамтын ажиллагааны (ИТЕС) хөтөлбөр Англи хэлний ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр II-т 3 албан хаагч хамрагдсан. 09 дүгээр сарын 25-ны өдрийн 1/267 тоот илтгэх хуудсаар таницуулагдсан. 4.2025.10.29-11.11-ний өдрүүдэд БНХАУ-ын элчин сайдын яам, Хятадын худалдааны яам болон Цахим засаглалын хөгжил сэдэвт сургалтад 3 албан хаагч хамрагдсан. 5.2025.09.16-10.17-ны өдрийн хооронд БНЭУ-ын ЗГ-ын Энэтхэгийн Техникийн эдийн засгийн хамтын ажиллагааны (ИТЕС) хөтөлбөр Англи хэлний ур чадварыг дээшлүүлэх хөтөлбөр II-т 1 албан хаагч хамрагдсан.
1.4.	Албан хаагчид мэргэшлийн зэрэг болон зэрэг дэв шинээр олгох, ахиулах, холбогдох хууль, журмын хүрээнд нэмэгдэл хөлсийг олгох;	Улсын төсөв	Шийдвэрлэгдсэн албан хаагчдын тоо	-	150	I-IV	Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур, Мэдээллийн технологийн албан хаагчид мэргэшлийн зэрэг олгох шалгуурыг А/35, А/36 дугаар тушаалаар батлуулсан.Үүнтэй холбогдуулан Мэдээллийн технологийн албан хаагчийн мэргэшлийн зэргийн түвшин тогтоох сорил авах Ажлын хэсгийн бүрэлдэхүүн А/69 дугаар
			Эзлэх хувь		20		

							тушаалаар батлагдан мэргэшлийн зэргийн түвшин тогтоох сорилын удирдамжийн дагуу холбогдох үйл ажиллагааг, шалгалтыг зохион байгуулж, түвшин тогтоон мэргэшлийн зэргийн нэмэгдлийг шинэчилэн тогтоож холбогдох нэмэгдлийг олгон ажилласан. 2025 оны Б/456, 457, 458 дугаар тушаалаар Төрийн захиргааны албан хаагчдад зэрэг дэвийн нэмэгдлийг шинээр 44, ахиулан олгосн 373 байна.
1.5.	Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, сахилга, ёс зүйг харгалзан байгууллага, салбарын болон төрийн одон, медальд тодорхойлох, дээд шатны байгууллага, албан тушаалтанд уламжлах;	-	Шагнагдсан албан хаагчдын тоо			I-III	Үндэсний их баяр наадмыг тохиолдуулан ерөнхий газар, нийслэл, дүүрэг, аймгийн газар, хэлтсийн нийт 51 албан хаагчийг төрийн дээд, 239 албан хаагчийг засгийн газрын шагналаар нийт 290 албан хаагчийг шагнуулахаар нэр дэвшүүлэн холбогдох материалыг ХЗДХЯ-нд хүргүүлсэн. Төрийн албаны зөвлөлд 10 албан хаагчийн материалыг хүргүүлсэн.
1.6.	Төрийн албан хаагчийн богино, дунд хугацааны болон мэргэшүүлэх багц сургалтад хамрагдсан талаарх мэдээлэл, судалгааг албан хаагч бүрээр хөтөлж, хүний нөөцийн нэгдсэн системд баяжилтыг тухай бүр оруулах, дараагийн шатны сургалтын хэрэгцээг тодорхойлж хэвших;	Улсын төсөв	Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо	2	5	I-IV	Удирдлагын академийн сургалтад төсвийн зардлаар ахлах түшмэлд 1, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалт 1, мэргэшүүлэх дунд хугацааны сургалт 3, чиглүүлэх сургалтад 5 нийт 10 албан хаагч хамрагдсан. Удирдлагын академийн сургалтад хувийн зардлаар эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2, ахлах түшмэлийн багц сургалтад 7, дунд

							хугацааны давтан сургалтад 7, нийт хувийн зардлаар 15 албан хаагч сургалтад хамрагдсан. Сургалтын мэдээлэл, судалгааг хүний нөөцийн нэгдсэн санд баяжилтыг тухай бүр оруулсан.
1.7.	Төрийн жинхэнэ албан хаагчдыг төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамруулах захиалга, хэрэгцээний судалгааг жил бүр шинэчлэн гаргах, үе шаттайгаар хамруулах, холбогдох байгууллагад тайлагнах;	Улсын төсөв	Хамрагдсан албан хаагчдын тоо	1	2	I-IV	Төрийн жинхэнэ албан хаагчдыг төрийн захиргааны тэргүүн, эрхэлсэн, ахлах түшмэлийн нийт 46 албан хаагчаас мэргэшүүлэх багц сургалтад 32 албан хаагч хамрагдсан, 2 албан хаагч хамрагдаж байгаа. 12 албан хаагчийг үе шаттайгаар хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.
1.8.	Албан хаагчдыг чадавхжуулах сургагч багш бэлтгэх.	Улсын төсөв	Сургагч багшийн тоо	2	3	I-IV	
Зорилт 2. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж, ажлын байрны орчин, нөхцөлийг дээшлүүлнэ.							
2.1.	Албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах хүрээнд төвийн болон орон нутгийн бүтцийн нэгжүүдийн ажлын байр, өрөө тасалгааны тохижилт, засвар үйлчилгээг тухай бүр хийх;	Улсын болон орон нутгийн төсвөөр.	Ажлын байр, өрөө, тасалгааны тоо	3	4	I-IV	Албан хаагчдын ажиллах орчин, нөхцөлийг сайжруулах хүрээнд ашиглалтын хугацаа дууссан, техникийн шаардлага хангахгүй, эдвсэрсэн, ашигладаггүй болсон 13 аймгийн авто машиныг байгууллагын данснаас хасуулах, актлах талаар байгууллагын Өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлтийг Төрийн өмч бодлого, зохицуулалтын газарт ХЗДХЯ-аар уламжлуулан хүргүүлсэн. ХЗДХЯ-ны шийдвэрийн дагуу Өвөрхангай аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийг автомашинтай болгосон нь төрийн үйлчилгээг орон нутагт хүргэх, албан

							хаагчдын ажиллах боломж сайжирсан болно.
2.2.	Албан хаагчдын ажиллах, амьдрах байрны нөхцөлийг орон нутгийн засаг захиргааны болон төсөл хөтөлбөрийн байгууллагатай хамтран орчин үеийн стандартад нийцүүлэх арга хэмжээг авах	Улсын төсөв, Санхүүгийн бусад эх үүсвэр	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	1	2	II-IV	Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгээр тус аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн Гурван тэс сумын улсын бүртгэгч нар зөөврийн тоног төхөөрөмжтэй болсон.
2.3.	Албан хаагчдыг орчин үеийн шаардлага, ажлын байрны онцлогт нийцсэн, ажлын бүтээмжийг нэмэгдүүлсэн цахим мэдээллийн систем, техник хэрэгслээр үе шаттайгаар хангаж, ажиллах орчин, нөхцөлийг дээшлүүлэх	Улсын төсөв, Төсөл хөтөлбөр	Шинэчилсэн техник хэрэгслийн тоо	20	30	I-IV	Азийн хөгжлийн банкны Техникийн туслалцааны санхүүжилтээр 200 сумдад эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг сайжруулах зорилгоор хэрэгжиж буй төслийн хүрээнд шаардлагатай техник, тогог төхөөрөмжөөр ханган ажилласан.
2.4.	Байгууллагын 49 ба түүнээс дээш насны албан хаагчийг нарийн мэргэжлийн оношилогоо, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулах, зохион байгуулах;	40,000.0	Хамрагдсан албан хаагчдын тоо	-	200	III-IV	Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын орон нутаг дахь салбар, нэгжид ажиллаж байгаа албан хаагчид, тэдний насанд хүрсэн гэр бүлийн гишүүдийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрт илрүүлэг хийх зорилтод арга хэмжээг дэмжин ажиллах, алба хаагчдаа бүрэн хамруулах ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын байдлаар Архангай аймгийн УБХ 20, Баян-Өлгий аймгийн УБХ 32, Говь-Алтай аймгийн УБХ "Говь-Алтай 80+" хөтөлбөрийн хүрээнд 21, Дархан-Уул аймгийн УБХ 22, Дундговь аймгийн УБХ 29, Дорнод аймгийн УБХ 31,

							Дорноговь аймгийн УБХ 31, Дорнод аймгийн УБХ 34, Баянзүрх дүүргийн УБХ 20, Орхон аймгийн УБХ 51, Өмнөговь аймгийн УБХ 34 албан хаагч (гэр бүлийн гишүүд)-ийг тус тус эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ оношлогоонд хамруулсан байна. Мөн Хууль зүйн салбарын албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэгт Төрийн албан хаагчийн эмнэлгийн албан хаагчид үзлэг, шинжилгээний тоног төхөөрөмжтэй явахаар 22 хоногийн унааны 9,5 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэсэн. III-IV улиралд байгууллагын 49 бай түүнээс дээш насны албан хаагчдыг нарийн мэргэжлийн оношлогоонд үнэ төлбөргүй хамруулахаар төлөвлөн ажиллаж байна.
2.5.	Эрүүл мэндийн шалтгаанаар гадаад, дотоодод эмчлүүлэхэд хөдөлмөрийн дотоод журамд зааснаар тусламж, дэмжлэг үзүүлэх, цалинтай чөлөө олгох;	Улсын төсөв	Өргөдөл, хүсэлтийн шийдвэрлэлтийн тоо	2	3	I-IV	Нийт 10 албан хаагчид эрүүл мэндийн шалтгаанаар гадаад, дотоодод эмчлүүлэхэд хөдөлмөрийн дотоод журамд зааснаар тусламж, дэмжлэг үзүүлж, цалинтай чөлөө олгон ажилласан.
2.6.	Хөрш болон бусад гадаадын улс, орнуудын төрийн байгууллагуудтай туршлага солилцож, хамтран ажиллах, төрийн албан хаагчдыг гадаад улс оронд сургалтад хамруулах;	Улсын төсөв	Хамрагдсан албан хаагчдын тоо	14	25	I-IV	1..БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (КОЙКА)-аас зохион байгуулсан Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан хаагчдын чадавхыг бэхжүүлэх ээлжит сургалтад 2025 оны 06 дугаар сарын 01-ний

							өдрөөс 14 өдрийн хооронд нийт 15 албан хаагч; 2.БНХАУ-ын элчин сайдын яам, Хятадын худалдааны яам болон Олон улсын бизнесийн академи(AIBO)-тай хамтран зохион байгуулсан Нэг бүс нэг зам дагуух улс орнуудын төрийн албан хаагчдад зориулсан Шинэ дэд бүтэц технологи ба менежмент сэдэвт сургалтад 2025.04.17-ны өдрөөс 30-ны өдрүүдэд 2 албан хаагч тус тус хамрагдсан. Мөн сургалтад 05 дугаар сард 1 албан хаагч хамрагдсан. 3.НҮБ-ийн Ази номхон далайн эдийн засаг, нийгмийн комисоос БНТУ-д /Турк/ Төв Азийн улс орнуудын иргэний улсын бүртгэлийн ажилтны уулзалтад 1 албан хаагч оролцсон. 4.“Смарткарт” ХХК-тай байгуулсан "Иргэний цахим үнэмлэх хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдах, худалдан авах" 2024/34-Н дугаартай гэрээний хэрэгжилтийг хангах хүрээнд Бүгд Найрамдах Турк улсын Истамбул хотод байрлах Энтраст компанийн салбарт 2025 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс 07 дугаар сарын 06-ны өдрийн хооронд "Хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тохиргоо, засвар үйлчилгээ"-ний
--	--	--	--	--	--	--	---

							сургалтанд 4 албан хаагч хамрагдсан. 5.Азийн хөгжлийн банкны техникийн туслалцааны хүрээнд хэрэгжиж буй "Сумдад эд хөрөнгийн эрхийн болон хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг цахимжуулах, нэвтрүүлэх замаар төрийн үйлчилгээг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах" төслийн санхүүжилтийн хүрээнд 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн А/126 тушаалаар 8 албан тушаалтан 2025 оны 06 дугаар сарын 27-ны өдрөөс 07 дугаар сарын 05-ны өдрийн хооронд Австралийн холбооны улсын ижил чиг үүргийн байгууллагуудын туршлага судлах сургалтанд хамрагдсан. 6.2025 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 1/2954 дугаартай албан бичгийн хүрээнд "Монгол Улсын хаягийн мэдээллийн системийг шинэчлэх" төслийн хүрээнд холбогдох төрийн байгууллагын албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, чадавхижуулах зорилгоор 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд БНСУ-д зохион байгуулагдсан сургалтад Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд оролцсон.
--	--	--	--	--	--	--	---

							7.БНХАУ-н 2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөс 11 дүгээр сарын 11-ний өдрийн хооронд “Хятад улсын Олон улсын Эдийн засгийн зөвлөх” ХХК-ийн зохион байгуулж буй “Бүс ба Зам” орнуудад зориулсан “Цахим засаглалын хөгжлийн семинарт” 3 албан хаагч хамрагдсан. 8.Олон улсын Архивын зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрөөс 13-ны өдрүүдэд БНСУ-д зохиогдох Зүүн Азийн бүсийн салбарын нэгдсэн чуулганд 4 албан хаагч хамрагдсан.
2.7.	Соёл, спортын болон ажил мэргэжлийн уралдаан тэмцээн зохион байгуулах;	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	2	I-IV	Улсын бүртгэлийн байгууллагын 85 жилийн ойг тохиолдуулан ажилтан, албан хаагчдын бие, бялдарыг хөгжүүлэх зорилго бүхий “Спорт-2025” нэгдсэн сургалтыг дартс, ширээний теннис, сагсан бөмбөг, гар бөмбөг гэсэн 4 төрлөөр 21 аймаг, нийслэл, дүүрэг, ерөнхий газрын албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.
2.8.	Албан хаагчийг илүү болон шөнийн цагаар ажилласан тохиолдолд нэмэгдэл хөлс олгох, нөхөн амрах, өөр аймаг, сум, хотод ажиллахад албан томилолт олгох, албаны автомашинаар аюулгүй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, албан томилолтын зардлыг жил бүрийн төсөвт суулгах.	Улсын төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	3	I-IV	Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх, Албан тушаалын, ажлын байрны тодорхойлолт шинэчилэн боловсруулах, батлуулах, Нийслэлийн улсын бүртгэлийн газрын архивыг нүүлгэхтэй холбоотой илүү цагаар

							ажилласан нийт 39 албан хаагчийн цагийн бүртгэлийг шалган тооцож Б/26, Б/269, Б/280, Б/347, Б/472, Б/533, Б/578 дугаар тушаалын дагуу нэмэгдэл хөлс олгосон.
Зорилт 3. Албан хаагчдын нийгмийн хамгааллын чиглэлийн судалгаа, бүртгэл мэдээллийг сайжруулж, тэдний нийгмийн баталгааг үе шаттайгаар дээшлүүлнэ.							
3.1.	Албан хаагчдын боловсрол мэргэжил, зэрэг дэв, мэргэшлийн зэрэг, улсад болон төрийн албанд, тухайн албан тушаалын ангилалд ажилласан хугацаа, ахуй амьжиргааны нөхцөл байдлыг тогтоох нийгмийн хамгааллын чиглэлийн бүртгэл судалгааг нарийвчлан гаргаж, түүнд баяжилт хийснээр баримт нотолгоонд үндэслэсэн шийдвэр гаргах нөхцөл, боломжийг бүрдүүлэх;	-	Хүний нөөцийн чиглэлээр гаргасан судалгааны төрлийн тоо	3	4	I-IV	Төрийн захиргааны албан хаагчдын албан тушаалын зэрэг дэвийг холбогдох журмын дагуу шинээр олгох 45, ахиулан олгох 383 албан хаагчийн судалгааг гарган Төрийн албаны салбар зөвлөлийн нарийн бичигт хүргүүлсэн.
3.2.	Албан хаагчийн орон сууцны нөхцөлийн судалгааг хийж, орон сууцжуулах, орон сууцны нөхцөлөө дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	Улсын төсөв, бусад эх үүсвэр	Хамрагдсан албан хаагчийн тоо	-	1	I-IV	ХЗДХ-ын сайдаар Улсын бүртгэлийн байгууллагын албан хаагчийн нийгмийн баталгааг хангах, орон сууцжуулах хөтөлбөрийг батлуулсан. Үүнтэй холбоотой А/96, А/97 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.
3.3.	Гэр болон ердийн галлагаатай байшинд амьдардаг албан хаагчид түлээ, нүүрсний хөнгөлөлт олгох, албан хаагчдын хүсэлт, амьжиргааны түвшнийг харгалзан холбогдох хууль тогтоомжийн дагуу тусламж, дэмжлэг олгох;	Улсын төсөв	Тусламж, дэмжлэг олгогдсон албан хаагчдын тоо	5	6	I-IV	УБЕГ-ын газар, хэлтэс, дүүргийн хэлтсийн нийт 47 албан хаагчид түлээ, нүүрсний хөнгөлөлт олгохоор тушаал гарсан.
3.4.	Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбоотой хүчирхийлэх, заналхийлэх,	-	Зохион байгуулсан	-	2	I-IV Т	Тайлант хугацаанд Албан үүргээ гүйцэтгэхтэй нь холбоотой

	доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл, үйл ажиллагаанаас албан хаагч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах ажлыг зохион байгуулах, эрх зүйн туслалцаа үзүүлэх;		арга хэмжээний тоо				хүчирхийлэх, заналхийлэх, доромжлох, гүтгэх болон бусад хууль бус үйлдэл гараагүй болно.
3.5.	Байгалийн давагдашгүй хүчин зүйлийн улмаас орон гэргүй болсон, эд хөрөнгийн хохирол учирсан албан хаагчид хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу санхүүгийн тусламж үзүүлэх;	Улсын төсөв	Тусламж авсан албан хаагчийн тоо	-	1	I-IV	Говьсүмбэр, Баянхонгор аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2 албан хаагчийн орон гэр галд шатсан тул хөдөлмөрийн дотоод журамд зааснаар тусламж дэмжлэг үзүүлсэн.
3.6.	Хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчийн нөхөн сэргээх эмчилгээ, туслах хэрэгсэл худалдан авах хүсэлтийг харгалзан дэмжлэг, тусламж үзүүлэх, ажлын цагийн зохицуулалт хийх, шаардлагатай чөлөө олгох.	Улсын төсөв, бусад санхүүгийн эх үүсвэр	Хамрагдсан албан хаагчийн тоо	1	2	I-IV	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй албан хаагчдийн ажлын цагийг богиносгох талаарх чиглэлийг Нийслэлийн Улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан.
Зорилт 4. Төрийн албаны тухай хууль, журмын хүрээнд агентлагийн хөдөлмөрийн дотоод журам болон шаардлагатай дүрэм, журмыг шинэчилж, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.							
4.1.	Албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрт нийцсэн дотоод үйл ажиллагааны журам боловсруулах, батлуулах;	Төсөв шаардахгүй	Шинэчилсэн болон нэмэлт өөрчлөлт оруулсан дүрэм, журмын тоо	-	1		Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилэх, Хүний нөөцийн журмыг батлуулахаар судалгааны ажлын хүрээнд ажиллаж байна.
4.2.	Хууль тогтоомжийн дагуу албан хаагчийн цалин хөлс, нэмэгдлийг тухай бүр олгох, холбогдох журмыг боловсруулан, батлуулах.		Журам батлагдсан байна	-	1	I-IV	Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалтны цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 238 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын дагуу Б/33 дугаар тушаалаар төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин хөлсийг шинэчилэн тогтоосон.